



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.06.29 № 3Г-1/73

танай _____-ны № _____-т

Хэлэлцээрийн төсөл зөвшилцөх тухай

“Батлан хамгаалах хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу уг хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Хэлэлцээрийн төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ


000264002959

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“9.ХЭЛЭЛЦСЭН нь: Хэлэлцээрийн төслийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Батлан хамгаалах хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэн дэмжээд, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх) хоорондын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа 1999 онд “Цэргийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний батлан хамгаалах яам хоорондын хэлэлцээр”-ийг байгуулснаар албан ёсоор эхэлж, өнөөдрийг хүртэл амжилттай хөгжиж ирсэн.

Хоёр улсын хооронд 2011 онд байгуулсан дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд 2012 оны 5 дугаар сард Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яаманд Батлан хамгаалахын атташегийн алба, 2015 оны 8 дугаар сард БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд Батлан хамгаалахын атташегийн албыг тус тус байгуулж, цэргийн дипломат албаар дамжуулан улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хувь нэмрээ оруулж байна.

Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх, бүс нутгийн хэмжээнд цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор хамтын ажиллагаагаа Засгийн газрын түвшинд хүргэхээр талууд харилцан тохиролцоонд хүрч, “Батлан хамгаалахын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулахаар төслийг эцэслэн тохиролцоод байна.

Тус хэлэлцээрийг байгуулснаар хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг бүх түвшний харилцан айлчлал, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, цэргийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хоорондын харилцааг өргөжүүлэх, цэргийн хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэргээр өргөжүүлэх ач холбогдолтой юм.

Уг Засгийн газар хоорондын хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6-д заасны дагуу заавал соёрхон батлуулах хэлэлцээрт хамаарна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**БАТЛАН ХАМГААЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар (цаашид “Талууд” гэх),

Хоёр улсын хооронд тогтсон найрсаг харилцааг харгалзан үзэж,

Батлан хамгаалахын хамтын ажиллагаагаар дамжуулан хоёр улсын одоо байгаа хоёр талт харилцааг улам өргөжүүлж, бэхжүүлэхийг эрмэлзэж,

Тэгш эрх, харилцан ашигтай байх болон Талуудын бүрэн эрхт байдлыг хүндэтгэх зарчимд үндэслэн хоёр улсын батлан хамгаалахын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьж,

Энэхүү Хэлэлцээрийг үндэсний болон олон улсын бодлоготой нийцүүлэн, үндэсний хууль тогтоомжтой зөрчилдөхгүй бөгөөд олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэгт сөргөөр нөлөөлөхгүй байдлаар хэрэгжүүлэхийг хүсэж,

Дараах асуудлыг харилцан тохиролцов.

**1 дүгээр зүйл
Зорилго**

Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь Талуудын харилцан ашиг сонирхолд нийцүүлэн мэдлэг, туршлага солилцох замаар батлан хамгаалахын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.

**2 дугаар зүйл
Талуудын эрх бүхий байгууллага**

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх Талуудын эрх бүхий байгууллага нь дараах байдалтай байна.

Монгол Улсын хувьд Монгол Улсын Батлан хамгаалах яам;

Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний батлан хамгаалах яам.

2. Хоёрдугаар зүйлийн 1 дэх заалтыг үл харгалзан, энэхүү Хэлэлцээрийн хүрээнд 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан батлан хамгаалахын тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамжийг шилжүүлэх, хүлээн авах, түр хугацаагаар оруулахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Монгол Улсын Батлан хамгаалах яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Батлан хамгаалах худалдан авалтын хөтөлбөрийн захиргаа байна.



3 дугаар зүйл
Батлан хамгаалах хамтын ажиллагааны хүрээ

1. Талууд өөрсдийн үндэсний хууль тогтоомж, дүрэм журам болон бодлогын хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллана:

а) Цэргийн боловсрол, сургалт, спорт, соёлын солилцоо болон мэдээлэл, туршлага солилцох замаар батлан хамгаалах салбарын хоёр талын харилцааг дэмжих;

б) Батлан хамгаалахын анагаах ухаан, шинжлэх ухаан, технологи, судалгаа болон хөгжлийн салбар дахь хамтын ажиллагааг дэмжих;

в) Батлан хамгаалах салбар дахь харилцан тохиролцсон бусад чиглэлийн хамтын ажиллагаа.

2. Энэ зүйлд заасан хамтын ажиллагааны тодорхой арга хэмжээг Талууд харилцан тохиролцож тодорхойлно.

4 дүгээр зүйл
Батлан хамгаалах бодлогын ажлын түвшний уулзалт

Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хянах, удирдах зорилгоор Талууд батлан хамгаалах бодлогын ажлын түвшний уулзалтыг тогтмол зохион байгуулна. Уулзалтыг Монгол Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсад ээлжлэн зохион байгуулна.

5 дугаар зүйл
Санхүүгийн зохицуулалт

1. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд аливаа арга хэмжээг зохион байгуулахдаа өөрөөр тохиролцоогүй бол айлчлал хийж буй Тал нь хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт байх хугацаандаа өөрсдийн үйл ажиллагааны зардлыг хариуцна.


2. Монгол Улсын Засгийн газар энэхүү Хэлэлцээрийн хүрээнд батлан хамгаалах тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамжийг шилжүүлэх, хүлээн авах түр хугацаагаар оруулахтай холбоотой үйл ажиллагаанд татвар, хураамж ногдуулахгүй.

6 дугаар зүйл
Нууц мэдээллийг хамгаалах

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд нууц мэдээллийг хамгаалах асуудлыг 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Сөүл хотноо байгуулсан "Цэргийн нууц мэдээллийг харилцан хамгаалах тухай хэлэлцээр"-ийн дагуу зохицуулна.

7 дугаар зүйл
Маргаан шийдвэрлэх

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргааныг зөвхөн Талууд хоорондын зөвлөлдөх, хэлэлцээ хийх замаар



шийдвэрлэнэ. Маргааныг үндэсний, олон улсын эсхүл гуравдагч талын аль ч шүүхэд шилжүүлэхгүй.

8 дугаар зүйл Төгсгөлийн заалт

1. Энэхүү Хэлэлцээр нь тодорхойгүй хугацаагаар байгуулагдах бөгөөд Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангасан тухай Талуудын сүүлчийн мэдэгдлийг дипломат шугамаар хүлээн авснаас хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Талууд харилцан бичгээр тохиролцсоны үндсэн дээр Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Ийм нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болно.

3. Аль нэг Тал нөгөө Талд бичгээр мэдэгдэн Хэлэлцээрийг хэзээ ч цуцалж болно. Ийм мэдэгдлийг нөгөө Тал хүлээн авснаас хойш 180 хоногийн дараа Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусгавар болно.

4. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусгавар болох нь Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж эхэлсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд нөлөөлөхгүй.

ҮҮНИЙГ НОТОЛЖ, энэхүү Хэлэлцээрт хоёр талын Засгийн газраас албан ёсоор гарын үсэг зурах эрх олгогдсон төлөөлөгчид гарын үсэг зурав.

Улаанбаатар хотноо 2026 оны 7 дугаар сарын-ны өдөр монгол, солонгос болон англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**



AGREEMENT BETWEEN THE GOVERNMENT OF MONGOLIA AND THE GOVERNMENT OF THE REPUBLIC OF KOREA ON DEFENSE COOPERATION

The Government of Mongolia and the Government of the Republic of Korea (hereafter referred to as the "Parties"),

Considering the prevailing friendly relations between the two states,

Desiring to enhance and strengthen the existing bilateral relationship through defense cooperation between the two states,

Intending to promote cooperation in the field of defense between the two states based on the principles of equality, mutual benefit and respect for each other's sovereignty, and

Desiring to implement this Agreement in accordance with the national and international policies of their respective states in a manner that does not contradict their national laws nor prejudice the obligations undertaken by their states at the international level,

Have agreed as follows:

Article 1 Purpose

The purpose of this Agreement is to enhance cooperation in the field of defense through the exchange of expertise and knowledge in the interest of both Parties.

Article 2 Authorized Bodies of the Parties

1. The authorized bodies of the Parties for the implementation of this agreement are as follows:

for Mongolia, the Ministry of Defence of Mongolia;

for the Republic of Korea, the Ministry of National Defense of the Republic of Korea.

2. Notwithstanding the provision of paragraph 1, the authorized body for the activities implementation under this Agreement in connection with the transfer and receipt or temporary admission of defense equipment and supplies of Article 5(2), is the Defense Acquisition Program Administration of the Republic of Korea, and the Ministry of Defense of Mongolia.

Article 3 Scope of Defense Cooperation

1. The Parties hereby agree to cooperate, within the framework of their national laws, regulations and policies, in the following areas:

a) promoting bilateral contacts in the area of defense through military education, training, sports and cultural exchanges and exchange of information and experience;

- b) promoting cooperation in the field of defense medicine, science, technology and research and development; and
- c) cooperation in other mutually agreed areas in the field of defense.

2. Specific cooperative activities in the areas set forth in this Article shall be mutually determined by the Parties.

Article 4

Defense Policy Working Level Talks

In order to monitor, manage and implement this Agreement, the Parties agree to host Defense Policy Working Level Talks. The Defense Policy Working Level Talks shall be hosted alternately in Mongolia and the Republic of Korea on a regular basis.

Article 5

Costs Arrangements

1. In the implementation of this Agreement, or any other activity arising hereunder, unless otherwise agreed, the visiting Party shall bear its own costs while in the territory of the host state.

2. The Government of Mongolia shall not impose any taxes or charges on activities conducted under this Agreement in connection with the transfer and receipt temporary admission of defense equipment and supplies.

Article 6

Protection of Classified Information

All aspects related to the protection of classified information in the framework of the defense cooperation under this Agreement shall be governed by the provisions of the Agreement between the Government of Mongolia and the Government of the Republic of Korea on the Protection of Classified Military Information, signed in Seoul on 15 February 2023.

Article 7

Settlement of Disputes

Any dispute arising from or connected with the interpretation or implementation of this Agreement shall exclusively be settled through consultation and negotiation between the Parties. The dispute shall not be referred to any national or international tribunal or third party for settlement.

Article 8

Final Provisions

1. This Agreement is concluded for an indefinite period and shall enter into force thirty (30) days after the date of the receipt of the later notification by the Parties through diplomatic channels of the completion of their internal procedures necessary for its entry into force.

2. This Agreement may be amended by mutual written consent of the Parties. Any such amendment shall enter into force in accordance with the same procedure as prescribed under paragraph (1) of this Article.

3. Either Party may terminate this Agreement at any time by giving written notification to the other Party. The Agreement will terminate on the one hundred eightieth (180th) day after such notification has been received by the other Party.

4. The termination of this Agreement shall not affect any on-going programs of activities under this Agreement, unless other mutually agreed by the Parties.

IN WITNESS WHEREOF, the undersigned, being duly authorized there to by their respective Governments, have signed this Agreement.

Done in duplicate at Ulan Bator, on the 00th day of July 2026 in the Mongolian, Korean, and English languages, all texts being equally authentic. In case of any divergence of interpretation, the English text shall prevail.

**FOR
THE GOVERNMENT OF MONGOLIA**

**FOR
THE GOVERNMENT OF THE
REPUBLIC OF KOREA**

대한민국 정부와 몽골 정부 간의 국방협력에 관한 협정

대한민국 정부와 몽골 정부(이하 "당사자"라 한다)는,
양국 간 지속하여 온 우호 관계를 고려하고,
국방협력을 통한 기존의 양국 관계를 강화하기를 희망하며,
양국의 주권에 관한 평등, 상호이익 및 존중의 원칙에 기반하여 국방 분야 내 협력을
도모하기를 바라고,
각 국의 국내법과 상충하지 아니하며 국제적 차원에서의 책무를 훼손하지 아니하는
선에서 각 국의 국내 및 국제 정책에 따라 이 협정을 이행하기를 희망하며,
다음과 같이 합의하였다.

제1조

목 적

이 협정의 목적은 당사자의 관심 분야 내 전문성 및 지식 교류를 통해 국방 협력을
증진하는 것이다.

제2조

당사자의 권한 당국

이 협정의 이행을 위한 권한있는 당국은 다음과 같다.

가. 대한민국을 위하여, 대한민국 국방부

나. 몽골을 위하여, 몽골 국방부

제1항의 규정에도 불구하고, 제5조 제2항의 방위장비 및 물자 이전, 인수 또는 일시적인
반입과 관련된 활동의 이행을 위하여 권한을 부여받은 당국은 대한민국 방위사업청과 몽골
국방부이다.

제3조

국방협력의 범위

당사자는 그들의 국내 법령 및 정책의 범위 내에서 다음의 분야에서 협력하기로 합의한다.

가. 군사교육, 훈련, 스포츠 및 문화교류, 정보 및 경험 교환을 통한 국방 분야에서 양자 교류
증진

나. 군사 의료, 과학, 기술, 연구 개발 분야 협력 증진, 그리고

다. 그 밖에 상호 합의된 국방 분야의 협력

이 조에 명시된 분야 내 세부적인 협력 활동은 당사자가 상호 결정한다.

제4조

국방정책 실무회의

이 협정의 관리, 감독 및 이행을 위하여 당사자는 국방정책 실무회의를 개최하는 것에 동의한다. 국방정책 실무회의는 정기적으로 대한민국과 몽골에서 교차로 개최한다.

제5조

비용 협의

당사자 간 별도로 합의하지 않는 한, 방문 당사자는 접수국 영역에서 발생한 이 협정의 이행 또는 그와 관련된 모든 활동 비용을 스스로 부담한다.

몽골 정부는 이 협정에 따라 수행되는 방위장비 및 물자 이전, 인수 또는 일시적인 반입과 관련된 활동에 대하여 어떠한 세금이나 수수료도 부과하지 아니한다.

제6조

군사비밀정보 보호

2월 15일 서울에서 서명된 대한민국 정부와 몽골 정부 간의 군사비밀정보의 보호에 관한 협정에 따른다.

제7조

분쟁 해결

이 협정의 해석 또는 이행 과정에서 발생하거나 그와 관련된 모든 분쟁은 당사자 간 협의를 통해서만 해결해야 하며, 국내 또는 국제 재판소나 제3자에게 해결을 의뢰하지 아니한다.

제8조

최종 조항

이 협정은 무기한으로 체결되며 당사자가 협정 발효를 위한 그들의 내부 절차가 완료되었음을 외교적 수단을 통해 전달한 마지막 통보의 접수일로부터 30일째 되는 날부터 발효한다.

이 협정은 당사자 간 서면 합의에 의하여 개정될 수 있다. 그러한 개정은 이 조 제1항에 규정된 것과 동일한 절차에 따라 발효한다.

어느 한쪽 당사자는 언제라도 다른 쪽 당사자에게 서면 통보를 통해 이 협정을 종료시킬 수 있다. 협정은 그러한 통보가 다른 쪽 당사자에게 접수된 후 180일째 되는 날에 종료한다.

이 협정의 종료는 당사자가 상호 합의하지 않는 한 이 협정에 따라 진행 중인 활동 또는 프로그램에 영향을 미치지 않는다.

이상의 증거로, 아래 서명자들은 그들 각자의 정부로부터 정당하게 권한을 위임받아

이 협정에 서명하였다.

이 협정은 2026년 7월 00일 울란바타르에서 동등하게 정본인 한국어, 몽골어 및 영어로 각 2부씩 작성되었다. 해석상 차이가 있을 때는 영어본이 우선한다.

대한민국 정부를 대표하여

몽골 정부를 대표하여

서명)

서명)

**“БАТЛАН ХАМГААЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН
ГАРАХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААР**

НЭГ. ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛАХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх) батлан хамгаалах салбарын харилцааг 1996 онд Цэргийн атташегийн түвшинд эхлүүлж, улмаар 1999 онд “Цэргийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний батлан хамгаалах яам хоорондын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулснаар хамтын ажиллагааны эрх зүйн чадамжийг сайжруулсан юм.

Энэ хугацанд хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа бүх түвшний харилцан айлчлал, зөвлөлдөх уулзалт, цэргийн боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, энхийг дэмжих ажиллагаа, хүмүүнлэгийн болон техникийн туслалцааны чиглэлээр тогтвортой хөгжиж ирсэн бөгөөд БНСУ-ын талаас одоогийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэн Засгийн газар хоорондын хэлэлцээр болгон бэхжүүлэх саналыг гаргасныг манай тал нааштай хүлээн авч, энэхүү “Батлан хамгаалах хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулах шийдвэрийн төслийг боловсруулсан болно.

“Батлан хамгаалах хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулах хэрэгцээ шаардлагын хувьд хоёр орны хамтын ажиллагааг илүү өргөн хүрээнд, тогтвортой хэрэгжүүлэх, цэргийн хамтарсан сургалт, бэлтгэлийг эрчимжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи шилжүүлэх, хамтарсан төсөл хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг шат ахиулахад оршиж байгаа болно.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хэлэлцээр байгуулснаар дараах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломж бүрдэнэ. Үүнд:

- Батлан хамгаалах бодлого, стратегийн асуудлаар зөвлөлдөх;
- Батлан хамгаалах байгууллагуудын харилцан айлчлал, уулзалтыг тогтмолжуулах;
- Цэргийн боловсрол, сургалт, боловсон хүчин бэлтгэх;
- Энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах;
- Батлан хамгаалах шинжлэх ухаан, судалгаа, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Гамшигтай тэмцэх, хүмүүнлэгийн ажиллагааны чиглэлээр туршлага солилцох;
- Буцалтгүй тусламж, техникийн дэмжлэгийг үр ашигтай хэрэгжүүлэх;
- Батлан хамгаалах салбарын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэх.

ГУРАВ. ӨНӨӨГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

БНСУ нь Монгол Улсын батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж ирсэн түнш орон юм.

2006-2024 оны хугацаанд БНСУ-ын Засгийн газар болон холбогдох байгууллагуудаас Монгол Улсын Зэвсэгт хүчинд радио холбооны тоног төхөөрөмж, цэргийн шүхрийн иж бүрдэл, сургалтын тоног төхөөрөмж, автомашин, барилга-инженерийн техник, гал унтраах болон эмнэлгийн зориулалттай холбогдох техник хэрэгсэл, хангамжийг буцалтгүй тусламжаар олгоод байна.

Эдгээр тусламж нь Зэвсэгт хүчний сургалт, бэлтгэл, инженерийн болон логистикийн чадавхыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байсан бөгөөд одоогоор зарим техник хэрэгсэл Зэвсэгт хүчинд ашиглагдаж байна.

ДӨРӨВ. ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛСНААР ГАРАХ ҮР НӨЛӨӨ

1. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт

- Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг Засгийн газар хоорондын түвшинд хүргэж, эрх зүйн баталгааг бэхжүүлнэ.
- Монгол Улсын Зэвсэгт хүчний сургалт, бэлтгэл, батлан хамгаалах салбарын мэргэжлийн боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- Энхийг дэмжих ажиллагаа, гамшгийн үед ажиллах чадавх, инженерийн болон техникийн боломжийг нэмэгдүүлнэ.
- Орчин үеийн батлан хамгаалах технологи, туршлагаас суралцах боломж өргөжнө.
- Цэргийн итгэлцэл, харилцан ойлголцол, бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна.

2. Гадаад бодлогын хүрээнд

- Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд БНСУ-тай стратегийн ач холбогдол бүхий хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- Хоёр улсын Иж бүрэн түншлэлийн харилцааг батлан хамгаалах салбарт шинэ түвшинд гаргана.
- Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаар харилцан ойлголцол, мэдээлэл солилцоог нэмэгдүүлнэ.
- Бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг дэмжих Монгол Улсын байр суурийг бэхжүүлнэ.

3. Нийгэм, эдийн засгийн үр нөлөө

- Буцалтгүй тусламж, техникийн дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.
- Батлан хамгаалах салбарт шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр авах боломж өргөжнө.
- Хүний нөөцийн чадавх сайжирснаар батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлтийн чанар дээшилнэ.

- Улсын төсөвт ирэх санхүүгийн ачааллыг тодорхой хэмжээгээр бууруулах эерэг нөлөө үзүүлнэ.

ТАВ. САНХҮҮ, ТӨСВИЙН НӨЛӨӨЛӨЛ

Хэлэлцээр нь зээл авах, улсын төсвөөс нэмэлт хөрөнгө гаргах шууд үүрэг үүсгэхгүй.

Харин батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд ирэх буцалтгүй тусламж, техникийн туслалцаа, сургалт, тоног төхөөрөмжийг хил, гаалиар нэвтрүүлэхтэй холбоотой татварын зохицуулалтыг олон улсын гэрээний хүрээнд шийдвэрлэх эрх зүйн боломж бүрдэнэ.

Ингэснээр төсвөөс татвар, хураамж төлөхтэй холбоотой хүндрэл багасаж, тусламжийн үр өгөөж бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэх юм.

ЗУРГАА. БОЛЗОШГҮЙ ҮР ДАГАВАР, ЭРСДЭЛ

Хэлэлцээрийн төсөл нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй. Мөн гадаад улсын цэргийн хүчин байршуулах, цэргийн эвсэл байгуулах, санхүүгийн өр төлбөр бий болгох, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсэн зарчимд өөрчлөлт оруулах, сөргөөр нөлөөлөх агуулгыг тусгаагүй болно.

ДҮГНЭЛТ

“Батлан хамгаалах хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулагдсанаар Монгол Улс, БНСУ-ын батлан хамгаалах салбарын олон жилийн уламжлалт харилцаа, хамтын ажиллагаа Батлан хамгаалах яамны түвшнээс Засгийн газар хоорондын түвшинд баталгаажиж, Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, буцалтгүй тусламж, техникийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, бүс нутгийн итгэлцэл, тогтвортой байдлыг хангахад бодит хувь нэмэр оруулах ач холбогдолтой байна.

Иймд уг хэлэлцээрийг байгуулж, Олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар соёрхон батлуулах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, гадаад харилцааны ашиг сонирхолд нийцэх юм.

---o0o---